Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

| | |
|---|---|
| Тайлагнах хугацаа: | 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | "БиДиСЕК ҮЦК" ХК<br>Регистрийн дугаар: 2052482<br>Улсын бүртгэлийн дугаар: 9010001030<br>Үнэт цаасны код: 522, BDS<br>Утас: 7555-1919 |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр | Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | Андеррайтер, брокер, дилерийн үйл ажиллагаа<br>Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа<br>Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах<br>Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер) |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо | Пантер Мидланд Аудит ХХК<br>2021 |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | 13,694,883 ширхэг |
| Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | Бэлтгэсэн: С.Дөлгөөн /Мэдээллийн ажилтан/<br>Хянасан: Б.Лхагвадорж /Гүйцэтгэх захирал/ |

| | | |
|---|---|---|
| 1. | Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ | |
| | Санхүүгийн байдлын үзүүлэлт | Жилийн санхүүгийн тайланг хавсаргав. |
| | Орлогын тайлан | |
| | Өмчийн өөрчлөлтийн тайлан | |
| | Мөнгөн гүйлгээний тайлан | |

| | |
|---|---|
| 1.1. | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт |
| | Пантер Мидланд Аудит ХХК-ийн зүгээс 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн БиДиСЕК |

| | | |
|---|---|---|
| | ҮЦК ХК болон түүний охин компаниудын нэгтгэсэн тайланд хөндлөнгийн аудит хийж гүйцэтгэн, **Зөрчилгүй** санал дүгнэлтийг үрүүлсэн.<br>Аудитын дүгнэлтийг хавсаргав. | |
| 1.2. | Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/ | |
| | Аудитын дүгнэлтийг хавсаргав. | |
| 2. | Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл | |
| 2.1. | Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ | Нийт хөрөнгийн өгөөж /ROA/= 0.159<br>Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/= 0.3053<br>Нэгж хувьцааны өгөөж /EPS/= 477,860<br>Үнэ ашгийн харьцаа /P/E ratio/= 0.003 |
| 2.2. | Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт | Ашигт ажиллагаа= 0.63<br>Эргэлтийн харьцаа=15.65<br>Санхүүгийн хөшүүрэг=1.91<br>Өрийн харьцаа= 0.48<br>Хөрөнгийн зохистой харьцаа/андеррайтерийн компанийн хувьд/=144.71 |
| 2.3. | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл | **Брокерийн үйл ажиллагаа**<br>2024 оны байдлаар компани брокерийн үйл ажиллагааны хүрээнд гадаад, дотоодын нийт 33,000 гаруй үнэт цаасны данс нээж, харилцагчийн бааз суурийг нэмэгдүүлэв. Мөн түүнчлэн МХБ-ийн арилжаанаас гадна Биржийн Бус Зах Зээлийн арилжааны хэмжээ, хөрөнгө оруулагчдын тоо тогтмол нэмэгдсээр байна. 2024 онд "БиДиСЕК ҮЦК" ХК нь МХБ дээр хийгдсэн нийт арилжааны 37.1% буюу 1.044 их наяд төгрөгийн арилжааг дангаар гүйцэтгээд байна.<br>**Андеррайтерийн үйл ажиллагаа**<br>- Андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд нийслэлээс гаргаж буй анхны бонд болох Улаанбаатар Бонд, анхны ногоон бонд болох "ХААН Банк" ХК-ийн бондыг тус тус олон нийтэд нээлттэй хэлбэрээр санал болгон амжилттай арилжаалсан. "Төрийн банк" ХК-ийн ногоон бонд"Сити Ойл" ХХК, "Цогц Зээл" ХХК-ийн хаалттай бондыг тус тус ББЗЗ-д санал болгон арилжаалсан.<br>Нийт 232.6 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэв.<br>**Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ**<br>- Компани нь зөвлөх үйлчилгээний хүрээнд "Монголын Хөрөнгийн Бирж" ХК "ХААН Банк" ХК, "АПУ" ХК, "Бодь Даатгал" ХК, "Тавантолгой" ХК гэх мэт нийт 15 хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг биетээр болон цахимаар зохион байгуулах, зөвлөмж өгөх, санал авах, тогтоол шийдвэрийн төслүүдийг боловсруулж хамтран ажиллав. Мөн хувьцаат компанийн ээлжит болон ээлжит бус |

| | | |
|---|---|---|
| | | хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайнаар зохион байгуулах www.agm.mn системийн шинэчлэн сайжруулалтын хүрээнд стресс тестийг гүйцэтгэж эмзэг байдлыг засварлах, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, зарим функцуудыг засварлах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.<br>**Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зуучлагч брокер**<br><br>- Компани нь 2023 оны 07 сарын 24-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх"-ийг зөвшөөрөв.<br>Тус шийдвэрийн хүрээнд холбогдох материалуудыг бүрдүүлэн өгч, улмаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 10 сарын 25-ны өдрийн шийдвэрээр "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл", Монголын Хөрөнгийн Биржийн 2023 оны 11 сарын 27-ны өдрийн шийдвэрээр "Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах зуучлагч (брокер)-ийн гишүүнчлэл"-ийг тус тус олгов. |
| 2.4. | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/ | - Тайлант хугацаанд тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй. |
| 2.5. | Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл; | - |
| 3. | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ | |
| | Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байхгүй. | |
| 4. | Цалин урамшууллын мэдээлэл | |
| | | |
| 5. | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл | |
| | Компани нь 2008 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр АНУ, Турк, Япон улсын нэр бүхий томоохон компаниудын удирдлага, хөрөнгө оруулагчдын төлөөлөгчид сонгогдсон бөгөөд одоогийн байдлаар 4 хараат бус гишүүнтэйгээр компанийн засаглалын зохистой харьцааг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй ба 1 жилийн бүрэн эрхийн хугацаанд үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн ТУЗ-ийн гишүүд нь 2024 оны 04 сарын 02-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдон ажиллаж байна. | |

| № | Нэр | Албан тушаал | ТУЗ дэх албан тушаал | Засаглалын гэрчилгээний дугаар | ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж буй хувьцааны тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Д.Даянбилгүүн | БиДиСЕК ҮЦК ХК-ийн Ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга | ТУЗ-ийн дарга | 0420034 | 465,436 |
| 2 | Б.Лхагвадорж | БиДиСЕК ҮЦК ХК-ийн Гүйцэтгэх захирал | Ердийн гишүүн | 0420027 | 2,377,150 |
| 3 | Н.Батгэрэл | БиДиСЕК ҮЦК ХК-ийн Тэргүүн дэд захирал | Ердийн гишүүн | 00048 | 338,014 |
| 4 | Uluc Bingol | Импера Капитал Дэд захирал | Ердийн гишүүн | 0430584 | |
| 5 | О.Уранбайгал | БиДиСЕК ҮЦК ХК-ийн Back office department, Vice President | Ердийн гишүүн | 0430673 | 881 |
| 6 | Хитоши Тани | Эгзэ Группийн Ерөнхийлөгч | Хараат бус гишүүн | 0420036 | |
| 7 | М.Туяа | "Шилдэг" сургууль, Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга | Хараат бус гишүүн | 0431250 | |
| 8 | Д.Амгаланбаяр | MSM ХХК, захиргааны мэргэжилтэн | Хараат бус гишүүн | 0430105 | 332,129 |
| 9 | Б.Энхбаяр | Санаа Эгзэ ХХК-ийн Гүйцэтгэх захирал | Хараат бус гишүүн | 0520013 | 100 |

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх түр хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон. Үүнд:

| *Нэр дэвшүүлэх хороо:* | | |
|---|---|---|
| Дарга: | М.Туяа | Хараат бус гишүүн |
| Гишүүд: | Б.Лхагвадорж | Ердийн гишүүн |
| | Улуч бингол | Ердийн гишүүн |

| *Аудитын хороо:* | | |
|---|---|---|
| Дарга: | Д.Амгаланбаяр | Хараат бус гишүүн |
| Гишүүд: | М.Туяа | Хараат бус гишүүн |
| | О.Уранбайгал | Ердийн гишүүн |

| *Цалин урамшууллын хороо:* | | |
|---|---|---|
| Дарга: | Б.Энхбаяр | Хараат бус гишүүн |
| Гишүүд: | Хитоши Тани | Хараат бус гишүүн |
| | Н.Батгэрэл | Ердийн гишүүн |

Компанийн гүйцэтгэх удирдлагын мэдээлэл:

| № | Нэр | Албан тушаал | Компанид ажилласан жил |
|---|---|---|---|
| 1 | Б.Лхагвадорж | Гүйцэтгэх захирал | 25 |
| 2 | Н.Батгэрэл | Тэргүүн дэд захирал | 25 |
| 3 | С.Дамдинсүрэн | IT алба, Захирал | 14 |
| 4 | Б.Онон | Харилцагчийн алба, Захирал | 6 |
| 5 | С.Дөлгөөн | Хөрөнгө оруулалтын алба, Захирал | 6 |
| 6 | О.Уранбайгал | Back Office алба, Vice President | 6 |
| 7 | Г.Билгүүн | Институционал харилцагчийн алба, Vice President | 1 |

6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

Компанийн 5-аас дээш хувь эзэмшигчдийн мэдээлэл:

| № | Нэр | Эзэмшлийн хувь |
|---|---|---|
| 1 | Zwahr Alexander | 24.73% |
| 2 | Д.Даянбилгүүн | 17.45% |
| 3 | Тасган Инвест ХХК | 15.32% |
| 4 | Монголиан Мастер Менежмент ХХК | 8.87% |
| 5 | Импера Монголиа Холдинг ЛТД | 6.25% |

8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

-

9. Ногдол ашгийн мэдээлэл

2024 оны нийт цэвэр ашгийн 19 хувь буюу үндсэн үйл ажиллагааны цэвэр ашгийн 60 хувь болох 1,228,020,158.61 төгрөг, нэгж хувьцаанд 89.67 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

10. Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

**Брокерийн үйл ажиллагаа:**



**Андеррайтерийн үйл ажиллагаа:**




**Зөвлөх үйлчилгээний хүрээнд:**




**Тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр**:

Компаниас Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын дунд уламжлал болгон зохион байгуулдаг BDSCup хөл бөмбөгийн тэмцээн 17 дахь удаагаа 2024 оны 9 сарын 14-ний өдөр амжилттай болж өндөрлөсөн.

BDSCup хөл бөмбөгийн 17 дахь удаагийн тэмцээнд Санхүүгийн Зохицуулах Хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК, "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК, "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК, "БиДиСЕК ҮЦК" ХК, "Голомт Капитал ҮЦК ХХК, "ТиДиБи Секьюритис ҮЦК" ХХК, "Гүүдсек ҮЦК" ХХК-ийн нийт 8 багийн 80 гаруй тамирчид оролцов.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

| |
|---|
| Овог, нэр:<br>Б.Лхагвадорж<br><br>Албан тушаал:<br>“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: …………………………………………..<br><br>(Тамга/тэмдэг) |
| Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: |
| Овог, нэр:<br>С.Дөлгөөн<br><br>Албан тушаал:<br>“БиДиСЕК ҮЦК” ХК Мэдээллийн ажилтан<br><br>Гарын үсэг: …………………………………………….. |

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо: 2025.02.24.

№ 25/09

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Би Ди Сек ҮЦК" ХК болон түүний охин компани "Би Ди Си Эй Пи" ХХК, "Их Чингис Хааны хөмрөг" ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 12-30 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

**Бусад мэдээлэл**

Компани нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч, хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалтай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг дуусах өдөр хүртэлх хугацаанд аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

**Номинал дансны талаар**

"Би Ди Сек ҮЦК" ХК нь өөрийн харилцагчдын арилжааны төлбөр тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах зорилго бүхий Худалдаа Хөгжлийн банканд байрших, 452644001 ам долларын, Голомт банканд байрших 1105391344 тоот ам долларын данс, Голомт банкны 1105057130 тоот төгрөгийн, Богд банкинд байрших 8160011183 тоот Төрийн банк дах 343100276403 тоот номинал дансны харилцагчийн мөнгөн гүйлгээний тайланг банкны хуулга болон анхан шатны баримт, мөнгөн хөрөнгө дамжсан данс бүрээр нь тулган шалгахад Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам", байгууллагын "Харилцагчийн мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо, гүйлгээний журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв хөтөлсөн байна.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болно.

**"Пантер Мидланд Аудит" ХХК**
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

## АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК**
(аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

| Дансны нэрс | 12/31/2023 | 12/31/2024 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 2,898,220,700.29 | 4,995,681,325.34 |
| Дансны авлага | 2,480,091,489.23 | 2,392,674,659.91 |
| Бусад авлага | 663,586,404.43 | 357,369,203.13 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 34,042,464,947.26 | 28,426,805,548.00 |
| Холбоотой талаас авах авлага | 124,707,512.67 | 312,639,711.45 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 443,961,599.46 | 759,208.46 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **40,653,032,653.34** | **36,485,929,656.29** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 4,286,593,093.38 | 4,480,793,269.01 |
| Биет бус хөрөнгө | 36,671,697.21 | 29,966,267.37 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 51,000,000.00 | 51,000,000.00 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **4,374,264,790.59** | **4,561,759,536.38** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **45,027,297,443.93** | **41,047,689,192.67** |
| **ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 1,567,061,210.71 | 1,343,947,339.50 |
| Цалингийн өглөг | 68,449,673.74 | 85,200,876.12 |
| Орлогын татварын өглөг | 34,545,907.63 | 38,018,488.57 |
| ХАОАТ-ын өглөг | 31,161,930.12 | 47,639,834.36 |
| НӨАТ өглөг | 1,272,238.52 | 1,859,085.92 |
| Урьдчилж орсон орлого | 477,871.18 | 477,871.19 |
| Нөөц (өр төлбөр) | 41,084,649.00 | 41,084,649.00 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 0.01 | 0.00 |
| Бусад өглөг /Номинол/ | 615,306,696.09 | 214,985,639.60 |
| Хүүний өглөг | 2,597,980.80 | 473,767,106.85 |
| ЭМНД-ийн шимтгэлийн өглөг | 33,769,802.93 | 39,735,526.00 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **2,395,727,960.73** | **2,286,716,417.11** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | |
| Урт хугацаат зээл | 27,327,536,422.46 | 17,325,330,905.83 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **27,327,536,422.46** | **17,325,330,905.83** |
| **Нийт өр төлбөр** | **29,723,264,383.19** | **19,612,047,322.94** |
| **Эзэмшигчдийн өмч** | | |
| Өмч: - төрийн | 0.00 | 0.00 |
| - хувийн | 0.00 | 0.00 |
| - хувьцаат | 9,326,763,118.32 | 9,326,763,118.32 |
| Нэмж төлөгдсөн капитал | 34,472.68 | 34,472.68 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,824,524,382.82 | 3,824,524,382.82 |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | (600,193,925.70) | (1,012,834,739.13) |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 2,752,905,012.62 | 9,297,154,635.04 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **15,304,033,060.74** | **21,435,641,869.73** |
| **НИЙТ ӨМЧ, ӨР ТӨЛБӨР** | **45,027,297,443.93** | **41,047,689,192.67** |

*12-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн*

## АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК**

(аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|
| **Үйл ажиллагааны орлого:** | **4,873,387,264.97** | **7,471,830,730.87** |
| Брокерийн үйл ажиллагааны | 1,677,612,491.78 | 3,636,763,527.76 |
| Андеррайтерийн үйл ажиллагааны | 784,616,211.50 | 2,036,200,000.00 |
| Хөрөнгө оруулалт менежмент хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний | 40,750,000.00 | 209,398,000.00 |
| Үнэт цаасны арилжааны цэвэр орлого | 2,286,270,394.08 | 1,395,185,761.24 |
| Диллерийн үйл ажиллагааны орлого | 84,138,167.61 | 194,283,441.87 |
| **Хөрөнгө оруулалтын орлого** | **476,893,322.03** | **1,680,026,550.75** |
| Ногдол ашгийн орлого | 109,711,735.73 | 1,025,870,120.75 |
| Бусад орлого | 169,710,946.66 | 433,730,207.49 |
| Түрээсийн орлого | 197,470,639.64 | 220,426,222.51 |
| Хүүний орлого | 1,460,648,306.75 | 1,311,953,271.95 |
| | **6,810,928,893.75** | **10,463,810,553.57** |
| **Борлуулсан хөрөнгө оруулалтын үнэт цаасны өртөг** | **0.00** | **0.00** |
| **Нийт ашиг /алдагдал/** | **6,810,928,893.75** | **10,463,810,553.57** |
| **Үйл ажиллагаа /борлуулалт, ерөнхий удирддлага/-ын зардал** | | |
| Үндсэн болон нэмэгдэл цалин | 1,408,554,546.50 | 1,697,632,370.06 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 175,278,716.50 | 209,568,490.87 |
| Засвар үйлчилгээний зардал | 82,226,304.55 | 71,712,236.11 |
| Ашиглалтын зардал | 117,674,352.99 | 37,371,893.60 |
| Сургалтын зардал | 6,142,000.00 | 10,091,700.00 |
| Албан томилолтын зардал | 61,643,125.93 | 117,690,144.42 |
| Бичиг хэргийн зардал | 45,777,919.38 | 33,307,630.00 |
| Тээврийн зардал | 0.00 | 940,150.00 |
| Шатахууны зардал | 24,771,376.00 | 23,287,444.00 |
| Элэгдлийн зардал | 155,002,107.31 | 171,213,608.26 |
| Зар сурталчилгааны зардал | 173,591,130.00 | 44,970,050.00 |
| Шуудан холбооны зардал | 81,192,735.48 | 103,441,261.52 |
| Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | 15,009,021.00 | 17,017,120.00 |
| Харуул хамгаалалтын зардал | 27,107,359.60 | 11,454,545.45 |
| Даатгалын зардал | 3,810,834.00 | 5,887,840.00 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 556,129,911.48 | 1,815,863,874.26 |
| Хүлээн авалтын зардал | 39,974,504.00 | 49,440,499.77 |
| Сонин сэтгүүл захиалгын зардал | 10,367,824.00 | 0.00 |
| Түрээсийн зардал | 14,280,000.00 | 14,245,840.00 |
| Шимтгэл хураамжийн зардал МХБ | 587,660,594.48 | 736,118,054.43 |
| Шимтгэл хураамжийн зардал ҮЦТХТ | 421,899,699.92 | 338,226,486.95 |
| Шимтгэл хураамжийн зардал СЗХ | 16,816,848.00 | 16,864,552.00 |
| *Гишүүнчлэлийн хураамж* | 36,989,999.91 | 24,798,469.00 |
| Бусад шимтгэл | 140,871,241.94 | 170,453,956.50 |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | **4,202,772,152.97** | **5,721,598,217.20** |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | **2,608,156,740.78** | **4,742,212,336.37** |
| **Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал )** | | |
| **Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал)** | 0.00 | 0.00 |
| Хүүгийн орлого | 0.00 | 0.00 |
| Хүү торгууль, хөнгөлөлтийн орлого | 0.00 | 0.00 |

| | | |
|---|---|---|
| Валютын ханшийн зөрүүгийн олз (гарз) | 240,416,321.09 | (37,158,288.97) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 32,302,711.71 | (84,226,483.23) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз гарз) | 0.00 | 35,730,911.46 |
| Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн олз | 457,620,216.12 | 4,618,841,184.01 |
| Санхүүгийн зардал | 2,040,641,887.58 | 2,507,085,707.91 |
| Бусад зардал | 11,598,548.91 | 23,180,379.09 |
| **Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдлын дүн /** | **(1,321,901,187.57)** | **2,002,921,236.27** |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **1,286,255,553.21** | **6,745,133,572.64** |
| **Орлогын татварын зардал** | 125,121,863.53 | 200,883,950.22 |
| **Татварын дараах ашиг /алдагдал/** | **1,161,133,689.68** | **6,544,249,622.42** |
| **Цөөнхөд ноогдох хувь** | 0.00 | 0.00 |
| **Ердийн ажиллагааны ашиг / алдагдал/** | **1,161,133,689.68** | **6,544,249,622.42** |
| **Онцгой шинжтэй зүйлс (цэвэр дүнгээр)** | 0.00 | 0.00 |
| **Тайлант үеийн цэвэр үр дүн** | **1,161,133,689.68** | **6,544,249,622.42** |

*12-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн*

# АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК**

(аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | **7,044,396,111.36** | **4,698,967,895.41** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого | 6,753,252,854.44 | 3,692,974,349.04 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 2,776,596.00 | 3,652,377.00 |
| Бусад мөнгөн орлого | 288,366,660.92 | 1,002,341,169.37 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **(15,895,336,307.40)** | **(13,689,191,735.19)** |
| Ажиллагчдад төлсөн | (1,045,015,964.37) | (1,276,558,711.16) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (309,201,606.64) | (380,700,646.69) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | (10,749,830,088.09) | (6,633,393,144.29) |
| Ашиглалтын зардалд төлсөн | (160,422,732.38) | (160,643,059.89) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | (24,966,937.00) | (37,706,935.00) |
| Хүүний төлбөрт төлсөн | (1,584,817,156.82) | (2,037,048,383.93) |
| Татварын байгууллагад төлсөн | (157,177,734.79) | (271,183,054.49) |
| Даатгалын төлбөрт төлсөн | (3,810,834.00) | (12,552,767.00) |
| Бусад мөнгөн зарлага | (1,860,093,253.31) | (2,879,405,032.74) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(8,850,940,196.04)** | **(8,990,223,839.78)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | 0.00 | 0.00 |
| Мөнгөн орлогын дүн (+) | **12,337,302,162.24** | **16,972,074,661.24** |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | 0.00 | 75,280,000.00 |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого | 11,160,929,191.87 | 15,426,618,949.54 |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан олголт | 1,176,372,970.37 | 1,470,175,711.70 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **(3,749,956,159.58)** | **(4,235,094,354.32)** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (56,441,372.00) | (58,760,280.00) |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | (853,170,528.75) |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа | (3,693,514,787.58) | (3,323,163,545.57) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **8,587,346,002.66** | **12,736,980,306.92** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | **80,855,664,139.04** | **155,805,125,593.05** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан | 26,270,907,484.58 | 6,849,602,208.89 |
| Бусад мөнгөн орлого | 54,584,756,654.46 | 148,957,672,384.16 |
| Төрөл бүрийн хандив | 0.00 | (2,149,000.00) |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **(80,079,155,590.76)** | **(157,450,778,325.13)** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | (5,366,363,291.10) | (11,236,875,709.82) |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | (14,943,575,791.55) | (5,081,373,385.87) |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | (13,027,303,844.78) | |
| Төлсөн ногдол ашиг | 0.00 | (412,640,813.43) |
| Бусад зардал | (46,741,912,663.33) | (140,719,888,416.01) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **776,508,548.28** | **(1,645,652,732.08)** |
| Валютын ханшийн зөрүү | (275,630,008.54) | (3,643,110.01) |
| **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **237,284,346.36** | **2,097,460,625.05** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,660,936,353.93** | **2,898,220,700.29** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **2,898,220,700.29** | **4,995,681,325.34** |

*12-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.221,31,213311*

# АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК**
(аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,369,488,300.00** | **7,957,309,291.00** | **3,824,524,382.82** | **(600,193,925.70)** | **1,591,771,322.94** | **14,142,899,371.06** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **Залруулсан үлдэгдэл** | **1,369,488,300.00** | **7,957,309,291.00** | **3,824,524,382.82** | **(600,193,925.70)** | **1,591,771,322.94** | **14,142,899,371.06** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 1,161,133,689.68 | **1,161,133,689.68** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 7,957,274,818.32 | (7,957,274,818.32) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **9,326,763,118.32** | **34,472.68** | **3,824,524,382.82** | **(600,193,925.70)** | **2,752,905,012.62** | **15,304,033,060.74** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 6,786,612.31 | **6,786,612.31** |
| **Залруулсан үлдэгдэл** | **9,326,763,118.32** | **34,472.68** | **3,824,524,382.82** | **(600,193,925.70)** | **2,759,691,624.93** | **15,310,819,673.05** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 6,544,249,622.42 | **6,544,249,622.42** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | (464,393,482.53) | 0.00 | **(464,393,482.53)** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **9,326,763,118.32** | **34,472.68** | **3,824,524,382.82** | **(1,064,587,408.23)** | **9,303,941,247.35** | **21,390,675,812.94** |

*12-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.*